

БАТЛАВ.
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН
ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙН ТӨВИЙН

ДАРГА  Ц.БАТДОРЖ



**“ДЭЛХИЙН УР ЧАДВАРЫН ТЭМЦЭЭН”-ИЙ
УР ЧАДВАРЫН ТҮВШИН ТОГТООХ ҮНЭЛГЭЭНИЙ
I ШАТНЫ УДИРДАМЖ ДААЛГАВАР**

(МЭРГЭЖИЛ: ӨРӨГ УГСРАГЧ)

Зохион байгуулагч байгууллага:

Монгол Улсын Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам
Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв
Мэргэжлийн боловсрол, сургалт - түншлэл ТББ
Монголын Барилгачдын Нэгдсэн Холбоо

Улаанбаатар хот
2020 он

Нэг. Ур чадварын түвшин тогтоох үнэлгээний зорилго

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын “Барилгын өрөг угсрагч” мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх, суралцагчдын ур чадварыг ахиулах, мэргэшүүлэх, урамшуулах, дэмжих, тэдний ур чадварын түвшинг олон улсын жишигт хүргэх замаар хөгжлийн чиг хандлага, мэргэжлийн чадвар чадамжийг тодорхойлон, 2021 онд БНХАУ-н Шанхай хотод болох “Дэлхийн ур чадвар”-ын 46 дахь тэмцээн”-д оролцох оролцогчийг сонгон шалгаруулахад оршино.

Хоёр. Үнэлгээ зохион багуулах газар, хугацаа

Ур чадварын түвшин тогтоох үнэлгээ 2020 оны 10 дугаар сарын 08-09 ны өдрүүдэд Улаанбаатар хотод Барилгын Политехник Коллежийн “Барилгын өрөг угсрагч” мэргэжлийн дадлагын байранд зохион байгуулагдана.

Гурав. Үнэлгээний хамрах хүрээ

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд 2021 оны 01-р сарын 01-ний байдлаар 22 нас хүрээгүй 1 суралцагчийг шалгаруулж, ур чадварын түвшин тогтоох үнэлгээнд оролцуулна.

Дөрөв. Үнэлгээний багийн бүрэлдэхүүн

“Монгол ур чадвар” үнэлгээний журамд заасан шалгуурыг хангасан, эрх бүхий үнэлгээний ажилтан, баталгаажуулагч байна.

Тав. Үнэлгээний нийтлэг шаардлага

- Үнэлгээнд оролцогч нь Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч бөгөөд тухайн сургууль нь албан ёсоор ур чадварын түвшин тогтоох үнэлгээнд оролцуулахаар нэр дэвшүүлсэн байна.
- Ур чадварын түвшин тогтоох үнэлгээнд оролцогч нь 2021 оны байдлаар 22 нас хүрээгүй байна
- Оролцогч нь ур чадварын түвшин тогтоох үнэлгээний ерөнхий зохион байгуулагчийн зүгээс тогтоосон оролцооны төлбөрийг үнэлгээ эхлэхээс 10 хоногийн өмнө зохион байгуулагчид төлсөн байна.
- Оролцогчид нь үнэлгээний удирдамж, техникийн баримт бичгийг мөрдөж ажиллана.
- Сонирхогчид тодорхой зайнаас ажиглаж болно.

Зургаа. Үнэлгээ зохион байгуулалах үе шат

Ур чадвар түвшин тогтоох үнэлгээг гурван үе шаттай зохион байгуулах бөгөөд нэгдүгээр шатнаас 5, хоёрдугаар шатнаас 2, гуравдугаар шатнаас нэг шилдэг оролцогчийг шалгаруулна.

Долоо. Үнэлгээ зохион байгуулалт

1. Үнэлгээнд оролцохыг хүссэн МБСБ-ын суралцагчийг 2020 оны 09 дугаар сарын 16-ны өдрөөс 09 дугаар сарын 30-ны өдрийн 17.00 цаг дуустал бүртгэнэ.

2. Оролцогч багш хоёр хавсралт анкетийн бөглөж, удирдамжинд заасан холбогдох бичиг баримтыг Монголын барилгачдын Нэгдсэн Холбооны байранд албан ёсоор авчирч бүртгүүлнэ. Нэг сургуулиас 1 оролцогчийг бүртгэнэ.

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, **PEACE TOWER** 11-р давхар, 1109 тоот
И-мэйл :Mongolian.builders.federation@gmail.com
Утас:314516,318685, 99061944

3. Оролцогчид бүртгүүлэхдээ дараахь материалыг бүрдүүлнэ.
 - Сургуулийн тодорхойлолт
 - Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ /эх хувиар/
 - 3x4 хэмжээтэй цээж зураг
 - Хураамж төлсөн баримт

4. Сургууль тус бүр оролцогчийн хураамжийг бүртгүүлэхээс өмнө төлсөн байх ба нэг оролцогчийн бүртгэлийн хураамж 500,000 төгрөгийг Монголын Барилгачдын Нэгдсэн Холбооны Худалдаа Хөгжлийн Банкин дахь 453035914 тоот дансанд /Дансны нэр: Монголын барилгачдын нэгдсэн холбоо, Регистр:1012509 тушаах ба гүйлгээний утган дээр сургууль, овог нэрийг бичсэн байна. Хураамж төлөгдөөгүй оролцогчийг бүртгэхгүй.

5. Үнэлгээ эхлэхээс 1 хоногийн өмнө буюу 10 сарын 07-ны 09.00 цагт Барилгын Политехник Коллежийн байранд техникийн зөвлөгөөнийг зохион байгуулна.

Зөвлөгөөнд:


- Оролцож буй сургуулиудын мэргэжлийн багш, оролцогч мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн баталгаажуулагч, үнэлгээчид оролцоно.
- Оролцогчдын мандатыг олгоно.
- Үнэлгээнд оролцогчдын даалгавахр гүйцэтгэх өдрийг сонгоно.
- Үнэлгээнд оролцож буй сургуулиудын багш нар зөөврийн компьютертэй ирэх бөгөөд AUTOCAD программ болон цахилгааны зураг, схем зурах программ суулгасан байх хэрэгтэй.
- Үнэлгээний даалгаврыг урьдчилан зарласан бөгөөд техникийн зөвлөгөөний дараа оролцогч сургуулийн мэргэжлийн багш, баталгаажуулагч үнэлгээний баг даалгаврын 30%-ийн өөрчлөлт болон үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулна.
- Оролцогч нь үнэлгээний ажлын байр болон багаж хэрэгсэл, цахилгаан тоног төхөөрөмжүүдийг шалгаж хүлээн авна.
- Зохион байгуулагч үнэлгээ хийх ажлын байр, түүнд хэрэглэгдэх материал, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийг бэлтгэнэ.
- Үнэлгээ хийх явцад ХАБЭА болон аюулгүй ажиллагааг зохион байгуулагч тал хариуцна.
- Үнэлгээнд оролцогч нь барилгын өрөг угсрагчийн ажил гүйцэтгэх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, журмыг чанд мөрдөнө.

- ХАБЭА-н мэргэжилтнийг Үнэлгээ зорион байгуулах ажлын хэсгээс томилон ажиллуулна.
- Үнэлгээг дуут дохиогоор эхэлнэ. Оролцогч 10 минут ба түүнээс дээш хугацаагаар хоцорсон тохиолдолд тэмцээнээс хасагдсанд тооцно.
- Орлцож буй болон ивээн тэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллага нь өөрийн онцлогийг харуулсан шинэ технологи, инноваци бүхий шилдэг бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж болно
- Үнэлгээний багийн бүрэлдэхүүн 100% ирцтэй байна.
- Оролцогчид үнэлгээнд орохдоо гар утасгүй орно.

Найм .Ажлын даалгавар

“Монгол ур чадвар-2020” түвшин тогтоох үнэлгээний ажлын даалгаварыг /зураг 1/ 5 цаг буюу 300 минутын хугацаанд гүйцэтгэнэ. Ажлын даалгаварт 30%-ийн өөрчлөлт оруулж техникийн зөвөлгөөний хурал дээр танилцуулна.

/Жич: Бэлтгэлийн хугацаанд ан заадсан дээр анхаарах/



Ес. Ур чадварын түвшин тогтоох үнэлгээнд хэрэглэгдэх гар багаж, хэмжих багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж. материал

Оролцогчид шаардлагатай гар багаж, хэмжин шалгах багаж хэрэгсэл, тоног төхөөрмжийг өөрсдөө бэлтгэн авч ирэх. Үүнд:

1. Цахилгаан багаж хэрэгсэл, тоног төхөөрмж:

а/ Цахилгаан багаж хэрэгсэл тоног төхөөрөмж нь 220В-оор ажилладаг байх шаардлагатай.

- Тоосго зүсэгч машин/сургуулиуд ашиглаж байгаа гар зүсэгч, тоосго зүсэгч машинаа авч ирэх./

- Уртасгагч залгуур

2. Хэмжих хэрэгсэл,

- Гортиг -1ш

- Балын харандаа, баллуур ком

- Шугам /1м хүртэлх урттай/ -1ш

- Метр -1ш

- Өнцөг хэмжигч 90⁰ -1ш

- Тэгш ус ком

- Рейк -1ш

3. Гар багаж

- Өргийн нийвий -1ш

- Ан заадас засагч -ком

- Өргийн алх

- Чиг утас -1ш

- Ажлын зураг гаргах цаас -багц

- Цаасны хутга -1ш

4. Материал болон зуурмаг

Даалгаварт ашиглагдах бүтэн тоосго, зуурмагт орох материал, зуурмагийг тэмцээний оролцогч бүрт зохион байгуулагч тал урьдчилан бэлдсэн байна.

5. Үнэлгээний хугацаа нийт 5 цаг байна. Үүнд цайны завсарлага, амралтын нэг цаг ороогүй.

Санамж:

- Ур чадварын түвшин тогтоох үнэлгээнд оролцогч нь хөдөлмөр хамгааллын хувцас өмсөж, хувийн бэлтгэлээ хангасан байна. Үүнд:

• Ажлын хувцас

• Хөдөлмөр хамгааллын нүдний шил

• Чихэвч эсвэл чихний бөглөө

• Ажлын гутал

• Хошуувч/ зүлгэлтийн үед ашиглах

• Анхны тусламжийн хувийн хэрэгсэл / Жишээ нь: эмчийн хяналтан дор байнга уудаг эм, үнэртүүлэгч, хурууны лент гэх мэт/

- Оролцогч нь ур чадварын түвшин тогтоох үнэлгээнд ашиглагдах хэмжин шалгах багажууд, тоног төхөөрөмжийг өөрөө бэлдэж, бүрэн ажилагаатай эсэхийг урьдчилан шалгаж бэлтгэл ажлыг хангасан байх.

Ес. Ур чадварын түвшин тогтоох үнэлгээнд оролцогчийн бүтээлд үнэлгээ өгөх, дүгнэх

Даалгаварыг эцсийн бүтээгдэхүүнээр үнэлэх, үнэлгээний баг шалгуур үзүүлэлтэд заасны дагуу шалгаж үнэлгээ өгөх ба дэлхийн ур чадварын тэмцээний стандартыг мөрдөн үнэлнэ.

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

- Ажлын байрны зохион байгуулалт, менежмент, ХАБЭА
- Ажлын зураг унших
- Өрөгт бүтээцийн хэмжилт
- Contraction буюу бүтээцийн угсралт, бүтээц
- Өргийн анг заадас, өрөгт бүтээцийн харагдах байдал, өрөгт бүтээцийг дуусгах

Үнэлгээний ажилтан бүр шалгуур үзүүлэлтүүдийг дүгнэхэд оролцож нэгдсэн оноог тавина. Авсан онооны дарааллаар байр эзлүүлнэ. Хөндлөнгийн баталгаажуулагч үнэлгээний явц, үр дүнгийн талаар дүгнэлт бичиж ҮМАЗТ-д ирүүлнэ.

2020.08.24